



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/236

Мандалговь

Төсөл, хөтөлбөр арга хэмжээний
санал батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 сарын 4-ний өдрийн 25 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 1 дугаар сарын 3-ны өдрийн 1 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 сарын 4-ний өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан "Хөтөлбөр арга хэмжээ"-ны зардлаас "Байгаль хамгаалахад хүүхдийн оролцоо анхдугаар чуулган"-ыг зохион байгуулахад 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

Хоёр. Арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга (Р.Баттүвшин)-д, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-д, ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200697